ХЭЭЛТЭГЧ ЭХ МАЛЫН ТОО, ТЭДГЭЭРЭЭС АВАХ СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ
(Мэдээлэл лавлагаа)

Ц.Болормаа, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

1. Улсын хэмжээний үнээ, эм хонь, эм ямаа, гүү, ингэний тоог аймаг, сум бүрээр
2. Монгол үнээ, сүүний чиглэлийн үнээ, сарлаг, хайнаг, эм хонь, эм ямаанаас нэг өдөрт саах сүүний хэмжээ, саалийн хугацаа, сүүн дэх тослогийн хэмжээ
3. Цагаан идээний импортын хэмжээ, нэр төрлөөр, үнийн дүнгээр
4. Улсын хэмжээнд хэрэглэх цагаан идээний хэрэгцээ нэр төрлөөр

Тус мэдээлэл лавлагааны ажлыг гүйцэтгэхдээ Үндэсний статистикийн хороо, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хүнсчдийн нэгдсэн холбооноос ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

1. Улсын хэмжээний үнээ, эм хонь, эм ямаа, гүү, ингэний тоо:

2013 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт хээлтэгч эх малын тоо *19 436 737* байх ба үүнээс эх малын төрлөөр нь авч үзвэл:

- Ингэ - 111 954,
- Гүү - 784 662,
- Үнээ - 1 150 971,
- Эм хонь - 9 094 872,
- Эм ямаа 8 294 275 тус тус байна.

Хээлтэгч эх малын тоог аймаг, сумаар нь нарийвчлан гаргасан бөгөөд аймгаар нь үзүүлбэл дараах тоон үзүүлэлт гарахаар байна. Үүнд:

Хүснэгт 1. Хээлтэгч эх малын тоо аймаг, нийслэл, 2013 оны дүнгээр

1	Улаанбаатар	152 533
2	Дорнод	551 097
3	Сүхбаатар	1 089 225
4	Хэнтий	1 336 745
5	Төв	1 602 141
6	Говьсүмбэр	124 902
7	Сэлэнгэ	614 232
8	Дорноговь	630 706
9	Дархан-Уул	133 821
10	Өмнөговь	660 840
11	Дундговь	817 740
12	Орхон	80 143
13	Өвөрхангай	1 387 797
14	Булган	1 239 036
15	Баянхонгор	1 205 070
16	Архангай	1 617 351
17	Хөвсгөл	1 636 863

18	Завхан	1 058 357
19	Говь-Алтай	915 793
20	Баян-Өлгий	687 056
21	Ховд	938 897
22	Увс	956 389
Нийт		**19 436 734**

Үндэсний Статистикийн Хорооноос 2013 оны байдлаар нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймгийн 330 сум тус бүрээр хээлтэгч эх малын тоог гарган ирүүлснийг хавсралтаас үзнэ үү. (Хавсралт 1)

2. Монгол үнээ, сүүний чиглэлийн үнээ, сарлаг, хайнаг, эм хонь, эм ямаанаас нэг өдөрт саах сүүний хэмжээ, саалийн хугацаа, сүүн дэх тослогийн хэмжээ:

“Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн”-гээс ирүүлсэн мэдээллээр эх малаас гарах 1 өдрийн сүүний гарц нь эрлийз үнээнд хамгийн өндөр буюу 3-8 литр байх бөгөөд 3.2-4.8 хувийн тослогтой байдаг байна.

Хүснэгт 2.

№	**Малын төрөл**	**Сүүний хэмжээ** *(1 өдөр.* **Литр)**	**Сүүний тослог** *(хувиар)*	**Саалинд хамрагдах хугацаа** *(хоногоор)*
1	Монгол үнээ	2.3-3.5	3.2-4.2	180-210
2	Эрлийз үнээ	3.0-8.0	3.2-4.8	305-320
3	Сарлаг	2.1	5.8-7.26	172-255
4	Хайнаг	3.9	5.62-6.4	240-288
5	Эм хонь	0.3-0.8	6.18	60-75
6	Эм ямаа	0.8-1.3	5.71	120

Хайнаг нь өдөрт 3.9 литр сүүний гарцтай бөгөөд 5.62-6.4 хувийн тослогтой байна. Хамгийн өндөр тослогтой сүү нь 5.8-7.26 хувийн тослогтой сарлагийн сүү бөгөөд нэг өдрийн сүүний гарц 2.1 литр байна. Монгол үнээний сүү хамгийн тослог багатай буюу 3.2-4.2 хувь ба нэг өдрийн сүүний гарц 2.3-3.5 литр байна.

Хонь болон ямааны сүү нь тослогийн хувьд харьцангуй тогтмол хэмжээтэй бөгөөд өндөр тослогтой болох нь хүснэгтээс харагдаж байна. Нэг өдрийн сүүний гарцын хувьд хонь, ямааны сүү нь үнээний сүүнээс харьцангуй бага буюу 0.3-1.3 литр байна.


Саалийн хугацааны хувьд эрлийз үнээний саалийн хугацаа хамгийн урт буюу 305-320 хоног, хайнаг үнээний хувьд 240-288 хоногийн саалийн хугацаатай байна. Хамгийн бага хугацаанд саах эх мал нь эм хонь буюу жилд 60-75 хоног байна.

Хүснэгт 3.

	Бойжуулсан төл, мян. тол	Саалинд хамрагдсан мал		1 малын жилийн сүүний гарц, кг	Сүүний үйлдвэрлэл	
		%	мян. тол		тонн	сая төг
Улсын дүн	15,221.9		9,163.3		575,223.2	590,814.4
Ингэ	49.2	58.3%	28.7	187.1	5,365.7	8,352.1
Гүү	550.6	55.5%	305.6	214.3	65,475.4	77,345.5
Үнээ	845.6	94.0%	794.4	479.4	380,830.3	370,005.7
Эм хонь	7,287.2	44.5%	3,242.0	12.7	41,226.2	42,999.6
Эм ямаа	6,489.3	73.9%	4,792.6	17.2	82,325.7	92,111.4

Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээллээр манай улс хуурай сүү, бяслаг, аарц, цөцгийн тос, шар сүү, тараг цагаан идээ, өтгөрүүлсэн сүү, хуурай сүү, цөцгий, шингэрүүлсэн сүү, цөцгий гэсэн нэр төрлийн сүү, цагаан идээг импортоор авч байна.

Импортоор авч байгаа сүү, цагаан идээний ихэнх хувийг өтгөрүүлсэн хуурай сүү болон хуурай сүү эзэлж байгаа бөгөөд 2013 оны байдлаар импортын сүү цагаан идээний 76.8 хувийг эзэлж байна. 2013 онд нийт 3,959 тонн хуурай сүү импортоор авсны 16.00 тонныг Австрали улсаас, Бүгд Найрамдах Солонгос Улсаас 81.39 тонныг, Оросын Холбооны Улсаас 8.55 тонныг, Шинэ Зеланд улсаас 3,811.10 тонныг, бусад улсаас 42.00 тонныг тус тус авсан байна. Манай улсын сүү цагаан идээний импортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа нь сүү цагаан идээний үйлдвэрлэл хангалтгүй байгааг харуулж байгаа юм.



2013 оны сүү цагаан идээний импортын хэмжээнд шингэн сүү 1.3 хувь, өтгөрүүлсэн хуурай сүү 44.5 хувь, хуурай сүү 27.9 хувь, өтгөрүүлсэн сүү 11.9 хувь, тараг 7.8 хувь, цөцгийн тос 1,0 хувь, бяслаг аарц 5.6 хувийг тус тус эзэлж байна.

Сүү, цагаан идээний импортын тоо хэмжээний өсөлт 2011 онд 33.1 хувиар, 2012 онд 25.4 хувиар өмнөх оныхоос өссөн бол 2013 онд 1.6 хувиар буурсан байна. Мөн манай улс 2010 онд 25609.3 мянган ам доллар, 2011 онд 35685.2 мянган ам доллар, 2012 онд 44185.8 мянган ам доллар, 2013 онд 44428.2 мянган ам долларыг цагаан идээний импортын үнэнд төлсөн байна.

Доорх хүснэгтэд 2010-2013 оны хооронд импортоор орж ирсэн сүү цагаан идээг нэр төрлөөр нь болон тоо хэмжээ, үнийн дүнгээр нь харууллаа.

Хүснэгт 4.

Барааны нэр	Хэмжих нэгж	Цагаан идээний импорт							
		2010		2011		2012		2013	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Сүү, цагаан идээ;			**мян.ам $**		**мян.ам $**		**мян.ам $**		мян.ам $
Шингэн сүү, цөцгий.	л	194 071.6	220.5	121 393.5	151.7	729 594.8	800.9	189 480.1	254.3
Өтгөрүүлсэн, хуурай сүү,	кг	3744 218.2	11 387.4	5162 680.5	16 228.9	6242 980.3	19 707.9	6340 109.2	19 440.0
Хуурай сүү	кг	2748 140.6	10 030.4	3536 156.0	13 464.0	4692 215.3	17 478.1	3959 176.7	15 932.1
Өтгөрүүлсэн сүү	кг	906 726.2	1 112.2	1466 848.2	2 091.6	1379 975.6	1 786.8	1689 092.1	2 317.4
Тараг, цагаан идээ.	кг	690 109.7	1 247.8	803 175.5	1 600.8	822 719.2	1 798.9	1110 113.8	2 231.3
Шар сүү	кг	7 084.0	7.3	5 892.0	4.9	2 363.4	5.0	6 852.6	7.2
Цөцгийн тос	кг	106 072.2	440.4	101 434.9	450.4	108 292.0	493.8	139 380.0	637.2
Бяслаг ба аарц	кг	275 287.6	1 163.3	346 353.6	1 692.8	493 433.4	2 114.5	801 890.8	3 608.8
Нийт	**кг**	**8671710.0**	**25609.3**	**11543934.2**	**35685.2**	**14471574.1**	**44185.8**	**14236095.2**	**44428.2**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2013 онд импортоор орж ирсэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг шингэн сүүнд шилжүүлсэн үзвэл дараах тоон үзүүлэлт гарч байна. 2013 онд 3,95 мянган тонн хуурай сүү импортолсныг шингэн сүүнд шилжүүлэн тооцвол 34 сая литр орчим байгаа нь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний 55%, нийт хэрэгцээний 7,4%-ийг эзэлж байна.

Хүснэгт 5.

Бүтээгдэхүүн	*Хэмжээ*	*Шингэн сүүнд шилжүүлснээр*
Шингэн сүү, цөцгий	189.48 тн	189.48 тн
Хуурай сүү	3,959.1 тн	34,840.08 тн
Өтгөрүүлсэн сүү	1,689.1 тн	1,684.1 тн
Цөцгийн тос	139.3 тн	3,066.36 тн
Бяслаг ба аарц	801.89 тн	6,415.12 тн
Нийт	**6778.87 тн**	**46195.15 тн**

4. Монгол Улсын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ:

Монгол Улсын хүн амын сүүний хэрэгцээ 2013 оны байдлаар 460,2 сая литр байгаа бөгөөд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж 13,7% байгаа хэдий ч орон нутагт уламжлалт аргаар үйлдвэрлэсэн сүү, цагаан идээний үйлдвэрлэлд 68,8 сая литр, цөцгийн тосны үйлдвэрлэлд 31,2 сая литр сүү ашиглагдаж байгаагаас гадна 260 орчим сая литр сүү ямар нэг бүртгэл хяналтгүй зах зээлд нийлүүлэгдэж байна гэсэн судалгааг Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас хийсэн байна.

Хүснэгт 6. 2013 оны сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Үнийн дүн
1	Боловсруулсан шингэн сүү	мян.л	26,607.40	35,584,438.70
2	Цөцгий	тн	15.2	101,171.30
3	Шимийн архи	мян.л	0.1	365
4	Тараг	мян.л	8,803.50	17,075,385.00
5	Хоормог	мян.л	3.7	9,507.60
6	Ааруул	тн	121.1	1,202,495.80
7	Цөцгийн тос	тн	148	1,062,178.20
8	Өтгөн цөцгий	тн	1,023.60	2,245,104.10
9	Өрөм, зөөхий	тн	2.8	13,535.00
10	Шар тос	тн	2.2	21,200.00
11	Масло	тн	0.1	756
12	Бяслаг	тн	13.2	156,503.00
13	Аарц	тн	127.5	689,264.80
14	Зайрмаг	мян.ш	19,656.70	3,932,167.70
15	Сүүний уураг	кг	49.7	117,024.00

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйгаас нийлүүлэх боломжит нийт сүүний нөөц 575,2 сая литр, үүнээс үнээний сүү 380,8 сая литр байна.[83] 2013 онд үйлдвэрийн аргаар 63,1 сая литр сүү боловсруулж, 44,5 тэрбум төгрөгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 45,3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Энэ нь 2012 онтой харьцуулахад сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 62,5 мян.тонноор өссөн гэсэн мэдээллийг хүнсчдийн нэгдсэн холбооноос гаргасан байна.

[83]Хүнсчдийн холбооноос эрхлэн гаргадаг сэтгүүлийн 2014 оны №1.

Манай улсын сүү, сүүн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг нэг бүрчлэн тооцоолон гаргах боломжгүй бөгөөд одоогийн байдлаар 2 арга замаар хэрэгцээг тооцож байна. Үүнд:

a) Улсын хэмжээний нийт үйлдвэрлэл дээр импортоор орж ирж буй цагаан идээг нэмж тооцоолох,
b) Эрүүл мэндийн сайдын 2008 оны "Хүн амын хоол тэжээлийн физиологийн нормыг батлах тухай" 257 дугаар тушаалд зааснаар нэг хүн жилд дунджаар 157 кг сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхийг зөвлөсөн норм байдаг. Үүний дагуу сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг тухайн жилийн нийт хүн амын тоогоор үржүүлэн тооцоолж гаргадаг.

Судалгаа шинжилгээний хэлтсээс 2011 онд хийсэн "Монгол Улсын хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарлын судалгаа, дүн шинжилгээ" судалгаагаар 2050 он хүртэлх Монгол Улсын хүн амын өсөлтийг таамагласны дагуу 2020 онд хүртэл манай улсын хүн ам дараах байдлаар өснө гэж үзээд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 7.

Он	***Хүн амын тоо (мянган хүн)***	***Сүү, цагаан идээний хэрэгцээ (сая литр)***
2014	2976.4	467.3
2015	3026.9	475.2
2016	3087.5	484.7
2017	3149.2	494.4
2018	3212.2	504.3
2019	3276.5	514.4
2020	3342.0	524.7